

Төслийн товчоон

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

2016 оны 1-р сар

Хэрэгжүүлэгч:



Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ БОДЛОГЫН ДЭМЖЛЭГ ТӨСӨЛ

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Хөтөлбөрийн нэр:

Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр

Төслийн нэр:

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл

Хугацаа:

2015 – 2018

Төсөв:

600,000 шв. франк

Зорилтот бүлэг:

Монгол Улсын Засгийн газар,
Бүх шатны засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж: аймаг, нийслэл, сум, дүүрэг
Монгол Улсын иргэд

Зорилтот бүс нутаг:

Үндэсний хэмжээнд

Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү ажлын хүрээнд Засгийн газраас Монгол Улсад захиргааны болон төсвийн төвлөрлийг сааруулах үйл явцыг дэс дараатай, харилцан уялдаа холбоотой, цогц байдлаар шийдвэрлэх үндсэн зорилго бүхий стратегийн баримт бичиг боловсруулах, мөн түүнчлэн Засгийн газрын болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг Монгол Улсын нөхцөлд тохируулан боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



Нийслэл, дүүрэг, хорооны чиг үүрэг, санхүүжилт, хариуцлагыг тодорхой болгоход дэмжлэг үзүүлнэ.

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс сүүлийн жилүүдэд төвлөрлийг сааруулах чиглэлээр нилээд санаачлага гаргаж, уг асуудлаар бодлогын болон хууль эрх зүйн салбарын түвшинд тодорхой өөрчлөлт шинэчлэлийн ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал: Улсын Их Хурлаас 2013 Төсвийн тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийг илүү тодорхой болгосон бөгөөд иргэдийн оролцоонд тулгуурласан Орон нутгийн хөгжлийн санг

хуульчилж өгснөөр орон нутгийн хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр болж байна. Хэдийгээр хууль эрх зүйн хүрээнд тодорхой ахиц дэвшил гарч байгаа хэдий ч Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад салбарын хуулиудад нутгийн удирдлагын байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхой бус засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хооронд эрх мэдэл, үүрэг хариуцлагын давхардал байсаар байна.

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газарт төвлөрлийг сааруулах цогц, харилцан уялдаа бүхий бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл хэрэгжсэнээр орон нутгийн засаг захиргаадын хэрэгжүүлэх чиг үүрэг, захиргааны эрх мэдэл, хариуцлага оновчтой, тодорхой болох нөхцөл бүрдэж, улмаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг төслийг Засгийн газар боловсруулна.

Төслийн зүгээс Монгол Улсад тохирсон, цогц, харилцан уялдаа холбоо бүхий төвлөрлийг сааруулсан засаглалын тогтолцоог бий болгоход шаардлагатай үзэл

баримтлал, аргачлал, бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжийн төсөл болон санхүүгийн тооцооллыг боловсруулахад Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлж ажиллана. Энэхүү ажлын хүрээнд Засгийн газар, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж хооронд чиг үүргийг зохистой хуваарилах, санхүүжүүлэх, орон нутгийн захиргааны болон улс төрийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах бөгөөд босоо болон хэвтээ чиглэлд хэрэгжүүлэх чиг үүргийг санхүүжүүлэх асуудлыг давхар авч үзэх юм.

ҮР ДҮН

- **Төвлөрлийг сааруулах стратегийн баримт бичиг.** Засгийн газрын Хэрэг эрхлэх газар чиг үүргийг дахин хуваарилах аргачлал бүхий төвлөрлийг сааруулах стратеги буюу бодлогын баримт бичиг боловсруулж Улсын Их Хурлын 2016 оны хаврын чуулганаар батлуулахаар төлөвлөж ажиллана.
- **Чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг сонгосон тухайн нэг салбарт турших.** Төслийн хүрээнд боловсруулах чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг цаашид улам боловсронгуй болгох зорилгоор тухайн аргачлалыг нийгмийн аль нэг салбарт турших бөгөөд ингэхдээ тухайн салбарын мэргэжилтнүүдийн оролцоотой Техникийн ажлын хэсэг байгуулж ажиллана.
- **Чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг нийгмийн бусад салбарт хэрэгжүүлэх.** Төслийн хүрээнд сайжруулан боловсруулсан чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг холбогдох яам, аймаг, нийслэл, сум, дүүргийн оролцоотой Техникийн ажлын хэсгүүдээр

хэлэлцүүлж салбар бүрт чиг үүрэг, төсвийн хуваарилалт хийх хэрэгцээ шаардлагыг судалсны үндсэн дээр хэрэгжүүлж, холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулна.

- **Төсвийн тэнцвэржүүлэлтийн өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох.** Орон нутгийн эдийн засгийн хүчин чадал, хөрөнгө нөөцийн ялгаатай байдлыг судалж орлого, зарлагын зөрүүтэй байдал, чиг үүргийг дахин хуваарилснаас үүдэн гарах санхүү, захиргааны үр нөлөөллийг тэнцвэржүүлэх замаар төсвийн тэнцвэржүүлэлтийн өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох талаар санал боловсруулна. Ингэхдээ нийслэл хотын онцлог байдлыг харгалзан үзнэ.
- **Бодлогын тасралтгүй дэмжлэг үзүүлэх.** Хууль эрх зүйн хүрээнд гарч буй өөрчлөлтүүд төвлөрлийг сааруулах бодлоготой уялдаж байгаа эсэхэд Төслийн нэгжийн зүгээс байнга ажиглалт, дүгнэлт хийж, төвлөрлийг сааруулах чиглэлээр гарч байгаа ахиц дэвшилд хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмол хийнэ.



Хамтын ажиллагааны гэрээнд талууд гарын үсэг зурлаа. 2015-09-08

Хамтран хэрэгжүүлэгч түншүүд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар,
- Сангийн яам,
- Салбарын яамд,
- Нутгийн удирдлагын байгууллагууд
- Люцерний Хэрэглээний шинжлэх ухаан, Урлагийн их сургууль

Холбоо барих:

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл

208 тоот, Монцамэ агентлагийн байр, Жигжиджавын гудамж-8, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: + 976 7575 2276

Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр

Скай Плаза Бизнес төв
2 давхар, Олимпын гудамж 12,
Хороо 1, Улаанбаатар хот,
Монгол Улс

Утас: +976 11328848

Факс: +976 11331420

Имэйл: ulaanbaatar@gdp.mn

Монгол дахь Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай плаза бизнес төв,
Олимпын гудамж 12,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Улаанбаатар хот

Ш/Х 37, Улаанбаатар 14210,
Монгол улс

Утас: +976 11 331 422

Факс: +976 11 331 420

И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch
Вэб хуудас: www.swiss-cooperation.admin.ch/mongolia